



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 08 дугаар
сарын 03 өдөр

Дугаар А/162

Улаанбаатар
хот

Зарим соёлын байгууллагуудын
харьяалалыг еөрчлөх тухай

1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14 дүгээр заалтыг үндэслэн Багануур, Налайх дүүргийн соёлын төв, номын сан, Багахангай дүүргийн соёлын төвийг 1995 оны 9 дүгээр сарын 1-нээр тасалбар болгон тус тусынх нь дүүргийн харьяалалд шилжүүлсүгэй.

2. Соёлын төв, Номын сангийн үйл ажиллагааны зардлыг 1996 оны төсөв төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэхийг Багануур дүүргийн Засаг дарга /н.Гавъяа-Оролцоо/, Налайх дүүргийн Засаг дарга /н.Жигжидсүрэн/, Багахангай дүүргийн Засаг дарга /н.Төмөрхүү/ нарт даалгасугай.

3. Дээрх дүүргүүдийн соёлын төв, номын санг зохих журмын дагуу дүүргүүдэд хүлээлгэн өгч мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Соёлын хэлтэс /н.Нямсамбуу/-т үүрэг болгосугай.

4. Дээрх дүүргүүдийн Соёлын төв, номын санг он дуустал үлдэж байгаа 4 сарын хугацаанд хотын төсвөөс санхүүжүүлэхийг Санхүүгийн хэлтэс /н.Гонгор/, Соёлын хэлтэс /н.Нямсамбуу/ нарт зөвшөөрсүгэй.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1995 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн А-30 тоот захирамжийн I хавсралтын "Төсвийн байгууллага" гэсэн хэсгийн II зүйлийн I дүгээр заалтын дүүргүүдийн номын сан, хот дүүргүүдийн соёлын төв гэсэн заалтаас дээрх дүүргүүдийн номын сан, соёлын төвийг хасч тус тусын дүүргийн харьяалалд нэмж оруулсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БОГООД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.Баасанжав

Ц.БААСАНЖАВ